

3

ҮНДЭСНИЙ ТООЦООНЫ СИСТЕМИЙГ ҮЕ ШАТТАЙГААР НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ЯВЦ, ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Бадамцэцэг, Б.Оросоо

1. Үндэсний тооцооны системийг нэвтрүүлэх талаар хүрсэн үр дүн

Хуучин социалист системийн улс орнуудын статистикийн арга зүйн гол цөм нь улс ардын аж ахуйн балансын систем байсан билээ. Энэхүү систем нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн нөхцөлд тохирсон, зах зээл хөгжсөн орнуудад зонхилж байсан үндэсний тооцооны системээс зарчмын ялгаатай байсан. Статистикийн үзүүлэлт тооцох (УТС) заарчмын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн Комиссоос батлан гаргадаг байлаа. Иймээс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгатай орнууд арга зүйн хувьд нэгдсэн, зохицуулсан, түүнийг нэгдсэн журмаар боловсруулж бэлэн хангадаг тогтолцоотой байсан.

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжилт хийж, 1992 оноос олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын гишүүн болсноор өөрийн орны талаархи статистик мэдээллийг олон улсын байгууллагуудад нийтлэг жишиг аргачлалаар бэлтгэж өгч байх шаардлага зүй ёсоор тавигдсан. Дотооддоо ч олон улсын статистикийн стандартыг нэвтрүүлж, зах зээлийн эдийн засгийн нөхцөлд тохирсон статистикийн арга зүйг хэрэглэх, олон улсын түвшинд зэрэгцүүлэх шаардлага гарсан.

Эл байдлыг харгалзан Монгол Улсын засгийн газар 1991 оны 3-р сарын 2-ны өдөр 71-р тогтоолоороо үндэсний тооцооны системд шилжих бэлтгэл хангах шийдвэрийг гаргасан. 1994 онд "Статистикийн тухай" бэлтгэл хангах шийдвэрийг гаргасан. 1994 онд "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийг парламент батлаж, уг хуулийг хэрэгжүүлэх тухай Засгийн газрын 94-р тогтоол 1994 оны 5-р сард гарсан бөгөөд энэхүү тогтоолоор олон улсын статистикийн стандартад шилжих хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийн нэг гол хэсэг нь үндэсний тооцооны системийг манай орны статистикийн практикт нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх явдал байлаа.

Манай орны статистикийн практикт УТС-ийг нэвтрүүлж ирсэн ажлыг дараах 3 гол үе шатанд хуваан авч үзэх нь зүйтэй. Үүнд:

- 1 үе шат: 1989- 1995 он
- 2 үе шат : 1996- 1998 он
- 3 үе шат : 1999 оноос хойши

Дотоодын болон үндэсний нийт бүтээгдэхүүнийг УТС-ийн аргачлалаар тооцох анхны тооцоо бүр 1989 онд хийгдсэн. Тэр үеийн эдийн засгийн гол үзүүлэлт болсон нийгмийн нийт бүтээгдэхүүн, үндэсний орлогыг дотоодын болон үндэсний нийт бүтээгдэхүүн болгон шилжүүлэх тусгай тооцооны аргыг хэрэглэж байв. Энэ аргыг тухайн үедээ хуучин ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд хэрэглэж байсан энэхүү аргачлалыг ашиглаж байлаа. Энэ аргаар тооцох тооцоог сайжруулж, хамрах хүрээг өргөжүүлэн 1995 он хүртэл шилжүүлэн тооцох энэхүү аргыг ашиглаж ирсэн. Энэ үе шатанд УТС-ийн онол арга зүйг судлах, орчуулах, манай орны нөхцөлд дотоодын болон үндэсний нийт бүтээгдэхүүнийг тооцох аргачлалыг боловсруулах, эдгээр үзүүлэлтийг үйлдвэрлэлийн аргаар оны болон зэрэгцүүлэх үнээр тооцох тооцоог 1980-оноос хойш хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. 1993 онд ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар, 1994 онд хүчин зүйлийн орлогын нийлбэр байдлаар анх тооцсон. Энэ бол УТС-ийг нэвтрүүлэх ажлын анхдагч маш чухал үе байсан.

Хоёрдогч шат 1996 оноос эхэлсэн. Учир нь 1995 оны гүйцэтгэлээр 1996 онд ДНБ - ийг улсын тайлан мэдээг үндэслэн шууд тооцох аргыг хэрэглэж эхэлсэн. 1995 он хүртэл ашиглаж байсан шилжүүлэн тооцох тооцооны аргыг үйлдвэр, аж ахуйн газруудаас цуглуулсан мэдээ тайланг үндэслэн шууд тооцох аргаар солисон нь энэ ажлын шинэ үе шат гэж үзэж болохоор зарчмын ахиц гарсан үе байлаа. Дээр дурдсан статистикийн олон улсын стандартад шилжих хөтөлбөрийн хүрээнд УТС-ийг нэвтрүүлэх ажлыг энэ үе шатанд улам эрчимтэй хэрэгжүүлж ирсэн. Энэ үед эдийн засгийн үйл ажиллагааны олон улсын салбарын стандарт ангилалд тулгуурласан үндэсний ангилал боловсруулах ажлыг 1995-1997 онуудад, салбар хоорондын балансыг УТС-ийн аргачлалаар боловсруулах зорилгоор маягт заавар боловсруулах, түүвэр судалгаа явуулах зэрэг бэлтгэл ажлуудыг 1998 онд хийж, уг балансыг 1999 онд 1997 оны гүйцэтгэлээр туршилтын журмаар зохиосон.

ДНБ-ийг эдийн засгийн сектороор тооцох, аймгуудад ДНБ- тооцох аргачлал боловсруулах ажлыг 1997-1998 онд тус тус хийж гүйцэтгэсэн нь УТС-ийг үе шаттайгаар нэвтрүүлэхэд чухал алхам болсон. Хоёрдах үе шатанд ДНБ-ийг салбараар тооцох аргачлалыг улам боловсронгуй болгох, хамрах хүрээг нь сайжруулах, түүнийг улирлаар тооцох, нэлээд аймгууд өөрсдөө ДНБ-ийг аймгийнхаа хэмжээнд тооцдог болсон зэрэг ажлууд хийгдсэн болно. УТС-ийг нэвтрүүлэх ажлыг хариуцсан бие даасан нэгж болох Үндэсний тооцооны хэлтсийг 1997 оны 11-р сард хуучин макро эдийн засгийн хэлтсийн суурин дээр байгуулж, үүрэг , хариуцах ажлыг

нь өөрчилсөн нь энэ ажлыг цаашид дагнан гүйцэтгэхэд чухал арга хэмжээ болсон.

Гурав дахь үе шат 1999 оноос эхэлсэн гэж үзэж болох бөгөөд энэ үед гол анхаарсан асуудал бол YTC-ийн нэвтрэлтийг цаашид эрчимжүүлэх, ялангуяа олон улсын нэгдмэл аргачлал болох НҮБ-ийн YTC-93-д нийцүүлэн өөрийн орны онцлогийг тусгасан аргачлал боловсруулан мөрдүүлэх, YTC-ийн гол дансуудыг байгуулах явдал байв. Энэ үед хийсэн нэг гол ажил нь ДНБ-ийг үйлдвэрлэлт, хувиарлалт, эцсийн ашиглалтын аргаар тооцох аргачлал боловсруулж, 2000 онд Сангийн яамтай хамтран баталсан явдал юм.

2001 оноос YTC-ын гол бүрэлдэхүүн хэсэг болсон үндэсний тооцооны гол дансыг сектороор, мөн бараа, үйлчилгээний данс байгуулж нэвтрүүлэв. YTC-ийн голлох дансуудийг дурьдавал:

- үйлдвэрлэлийн
- орлого бүрдэлтийн
- орлогын анхны хуваарилалтын
- орлогын дахин хуваарилалтын
- орлого ашиглалтын
- хөрөнгийн
- бараа, үйлчилгээний

гэсэн 7 гол данснуудыг 1995-2000 оноор байгуулсаны дотор ХАА -13 гол нэрийн бүтээгдэхүүнээр болон аж үйлдвэрийн 60 дэд салбараар бараа, үйлчилгээний 73 дансуудыг байгуулсан. 2000 онд 1999 оны гүйцэтгэлээр ДНБ-ийг аймгаар тооцдог болсон нь улс орны эдийн засагт бус нутгийн болон аймгуудын оруулах хувь нэмрийг тодорхойлох чухал мэдээлэлтэй болов. Нөөц ашиглалтын балансыг туршилтын журмаар байгуулж, бараа, үйлчилгээний данснуудыг бий болгосон нь ДНБ-ний тооцооны үндэслэлийг сайжруулж, үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын тооцоог уялдуулах зэрэг ач холбогдол бүхий ажил болсон юм. Гуравдахь үе шатанд ДНБ-нд хувийн хэвшлийн эзлэх хувь хэмжээг салбараар тооцдог босон нь эдийн засаг дахь хувийн секторын эзлэх байр суурийг тодорхойлсон чухал үзүүлэлт болов.

Гуравдагч үе шат өнөөг хүртэл үргэлжилж байгаа бөгөөд YTC-ийн үлдсэн гол данснуудыг бүрэн байгуулж дуусгах асуудал цаашдын гол зорилт гэж бид үзэж байна.

Өнгөрсөн хугацаанд YTC-ийг нэвтрүүлэх ажлыг хариуцсан нэгжийг бэхжүүлсний зэрэгцээ боловсон хүчиний чадавхийг сайжруулахад нилээд анхаарсан.

Эдгээр үе шатны ажлуудыг хэрэгжүүлсэний дунд бид одоо дараах гол үр дүнд хүрээд байна. Үүнд:

YTC-ийг нэвтрүүлэх тулгуур баримт бичиг болох НҮБ-ын 1993 оны YTC-ийн арга зүйд тулгуурлан ДНБ-ийг улсын дүн болон аймгаар, улирлаар тооцох аргачлал, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын, бүтээгдэхүүн, үйлчилгээний, эдийн засгийн секторын ангилал, үндэсний тооцооны

дансуудыг байгуулах, салбар хоорондын баланс зохиох, далд эдийн засгийн хэмжээг тооцох аргачилсан зөвлөмж зэрэг нийт 12 аргачлал, зөвлөмжийг 1998-2002 онд боловсруулж, өмнөхийг шинэчлэн сайжруулан батлуулж, тэдгээрийг мөрдөн ажиллаж байна.

YTC-ийн хүрээнд үндсэн 3 ангиллыг нэвтрүүлээд байна. Үүнд:

- a) Эдийн засгийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангиллыг үндэслэсэн үндэсний ангилалыг боловсруулж, түүний дагуу ДНБ-ийг 1995-2002 оноор тооцсон.
- b) Эдийн засгийн секторын ангиллын ерөнхий аргачлалыг боловсруулж, 1995-2000 оны гүйцэтгэлээр Үндэсний тооцооны эхний 6 дансыг секторын ангиллаар тооцлоо.
- v) Бүтээгдэхүүний нэгдсэн ангиллын аргачлалыг боловсруулж, 2001 оноос туршилтын журмаар мөрдөж эхлээд байна.

1998 онд явуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тооплогыг үндэслэн бизнес регистрийн санг анх удаа бий болгов. Бизнес регистрийн санг улирал тутам шинэчилж байгаа бөгөөд энэхүү регистр нь дотоодын нийт бүтээгдэхүүний хамралтын хүрээг тогтоох тулгуур мэдээлэл болдог юм.

ДНБ-ий тооцоог боловсронгуй болгох чиглэлээр нэлээд ажлууд хийгдэв.

Үүнд:

- Албан ёсны статистик мэдээллийн маягуудын 84.2 хувийг 1996 оноос хойш шинэчлэн баталж мөрдүүлэв.
- ДНБ-ий эцсийн ашиглалтын үндсэн хөрөнгийн хуримтлалыг үндсэндээ хөрөнгө оруулалтаар авч тооцож байсныг өөрчилж, ДНБ-ий эцсийн ашиглалтын шинэчилсэн аргачлалын дагуу 1995-2002 оны тооцоог хийсэн.
- Аймаг орон нутагт ДНБ-ий тооцоог 1999-2001 оноор хийж, уг ажлыг тогтмолжууллаа.
- Улирлын ДНБ-ий тооцоог 1995 оны зэрэгцүүлэх үнээр 1995-2002 оноор туршилтын журмаар хийсэн.
- Албан бус секторын судалгааг анх удаагаа 1997 онд, хоёр дахь удаагаа 1999 онд явуулж судалгааны дунг ДНБ-ий 1997-2002 оны гүйцэтгэлд нэмж тусгасан.

Үндэсний тооцооны данс, балансуудын тооцоог нэвтрүүлэх ажил нэлээд эрчимтэй хэрэгжиж байна. Үүнд:

- YTC-ийн үндсэн дансууд болох үйлдвэрлэлийн, орлого бүрдэлтийн, орлогын анхны болон дахин хуваарилалтын, орлого ашиглалтын, хөрөнгийн болон бараа үйлчилгээний дансыг улсын түвшинд 1995-2001 оноор байгуулсны зэрэгцээ үйлдвэрлэлийн болон орлого бүрдэлтийн, орлогын анхны болон дахин хуваарилалт, орлого ашиглалт, хөрөнгийн дансыг эдийн засгийн сектороор байгуулав. Мөн бараа үйлчилгээний дансыг улсын түвшинд 1995-2001 оноор байгуулав.
- Үндэсний тооцооны системийн арга зүйд нийцүүлсэн салбар хоорондын балансыг 1997, 2000 оны гүйцэтгэлээр боловсруулсан.
- Нөөц ашиглалтын балансыг 1997 оны гүйцэтгэлээр туршилтаар байгуулсны зэрэгцээ, 1999, 2000 оны гүйцэтгэлээр дахин байгууллаа.

Түүнчлэн 1999, 2000 оны гүйцэтгэлээр бараа, үйлчилгээний дансыг хөдөө аж ахуйн 20, аж үйлдвэрийн 100 гаруй гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр байгуулсан.

2. Хүрсэн үр дүнг олон улсын хэмжээнд зэрэгцүүлсэн байдал

ҮTC нэвтрүүлэх талаар манай оронд хийсэн ажлыг олон улсын түвшинд зохих ёсоор үнэлсэн. 1999 оны 3 сард Нью-Йорк хотноо хуралдсан НҮБ-ын Статистикийн Комиссын 30 -р хуралдаан дээр ҮTC-ын 1993 оны аргачлалыг улс орнууд хэрхэн нэвтрүүлсэнийг дүгнэсэн байдаас үзэхэд Монгол Улс 1990-1995 оны үзүүлэлтээрээ тэг түвшинд байсан бол 1992-1997 оны 1990-1995 оны үзүүлэлтээрээ нэгдүгээр түвшинд дэвшиж орсон гэж дүгнэгдсэн болно. Үзүүлэлтээрээ нэгдүгээр түвшинд дэвшиж орсон гэж дүгнэгдсэн болно. Дэлхийн 185 орныг хамруулсан энэхүү үнэлгээгээр тэдний 35.7 хувь нь буюу 66 орон тэг түвшинд, 20 хувь нь буюу 37 улс 1-р түвшинд, 29.2 хувь нь буюу нийт 54 орон 2-р түвшинд орсон орнууд байлаа. Хамгийн дээд буюу нийт 54 орон 2-р түвшинд орсон орнууд байв. Эндээс үзэхэд манай түвшинд АНУ, Канад улсуудыг оруулсан байв. Эндээс үзэхэд манай түвшинд АНУ, Канад улсуудыг оруулсан байв. Эндээс үзэхэд манай түвшинд АНУ, Канад улсуудыг оруулсан байв. Гэхдээ бидэнд цаашдаа түвшингээ ахиулахын тулд хийх ажил их байна.

НҮБ-ын ажлын тусгай хэсэг дэлхийн улс орнуудад ҮTC-ийн 1993 оны шинэ аргачлалын нэвтрэлтийг 7 үндсэн үе шатаар тодорхойлсон. Түвшин тус бүрд ямар ажлууд хийгдсэн байхыг доор харуулав.*
1-р үе: ҮTC-ийг нэвтрүүлэх эхний шатандaa яваа, 1-р түвшний ажлыг бүрэн хийгээгүй орнууд
2-р үе: ДНБ –ий тооцоо, салбараар, оны ба зэрэгцүүлэх үнээр, эцсийн аргаар тооцох
3-р үе: Дээрхээс гадна макро эдийн засгийн гол үзүүлэлтийг тооцсон, эдийн засгийн гадаад дансыг бүрэн байгуулсан байх


4-р үе (секторын дансны 1-р шат): Үйлдвэрийн данс 5 сектороор, орлого, хөрөнгө санхүүгийн дансуудыг улсын байгууллагын сектороор байгуулах

5-р үе (секторын дансны дунд шат): Орлого, хөрөнгө, санхүүгийн дансуудыг үлдсэн бүх секторээр байгуулах

6-р үе: Бусад урсгал дансууд болон актив, пассивын балансыг зохиосон байх

*Үнэлгээг НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газарт жил бүр нөхөж хүргүүлдэг асуултын нөхөлт, бүрэн байдлыг харгалзан дүгнэдэг.

ҮTC-ийн 1993 оны аргачлалын нэвтрэлтийг бүс нутаг, улс орноор харуулбал



1997 оноос хойш ҮСГ нь үндэсний тооцооны системийг нэвтрүүлэх талаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж Дэлхийн банк болон НҮБ-ын ХАА-н байгууллагуудын тусlamжтайгаар 3 удаагийн томоохон төслийг хамтран хэрэгжүүлээд байна. Төслүүдийг тус бүрд нь авч үзвэл.

1. Дэлхийн Банкны тусlamжтайгаар хэрэгжсэн "ҮСГ-ын хүчин чадлыг өргөжүүлэх" төсөл

Энэ төслийн хүрээнд ҮСГ-т хийгдэх гол ажил нь 1997, 1998 оны Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) тооцоон дээр үндэслэн "Нөөц Ашиглалтын Баланс" (НАБ) байгуулах явдал байсан юм.

"НАБ"-ийг байгуулах нь ҮСГ-т хийгдэж буй ДНБ-ий тооцоо, түүнтэй холбоотой мэдээллийн эх үүсвэр, мэдээллийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, зайлшгүй авах шаардлагатай мэдээллийн жагсаалтыг гаргахад чухал ач холбогдолтой байв.

ҮСГ нь Салбар хоорондын балансыг зах зээлийн шинэ системийн үед анх удаа 1997 оны байдлаар хийсэн. Энэ тооцоог хийхэд ашигласан судалгааны материалыг "НАБ"-ийг байгуулах явцад ашигласан бөгөөд макро түвшний балансуудыг зохиоход мэдээллийг хэрхэн ашиглах, мэдээллийн эх үүсвэрийг хэрхэн сонгох, мэдээллийн маягтыг хэрхэн боловсруулах, мэдээлэлд дун шинжилгээ хэрхэн хийх талаар өргөн мэдлэг олгосноороо ач холбогдолтой болсон юм.

2. НҮБ-ЫН ХХАА-Н БАЙГУУЛЛАГЫН ТУСЛАМЖТАЙГААР ХЭРЭГЖСЭН “ХӨДӨӨ АЖ АХҮЙН, ЭДИЙН ЗАСГИЙН ДАНСНЫ СУРГАЛТ” ТӨСӨЛ

Манай улсад YTC-ийг нэвтрүүлэх ажлын хүрээнд эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэдэг ХАА-н салбарт эдийн засгийн данс байгуулах ажлыг туршилтын журмаар хийх шаардлага тавигдсан юм.

Үндэсний статистикийн газраас НҮБ-ын Хүнс, ХАА-н байгууллагын (ХХААБ) санхүүгийн дэмжлэгтэйгээр ХАА-н түүвэр судалгааг 1994 онд анх удаа, 1998-1999 онд 2 дахь удаагаа явуулсан.

Эдгээр судалгаа нь ХАА-н салбарын нэмэгдсэн өргтийг олон улсын стандарт аргачлалд нийцүүлэн тооцох, улмаар эдийн засгийн дансыг байгуулахад шаардлагатай суурь мэдээллийг бий болгосноороо ач холбогдолтой байлаа.

3. Дэлхийн банкны тусlamжтайгаар хэрэгжүүлсэн “Нөөц ашиглалтын хүснэгт зохиох “дэд төсөл

Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр манай газарт хэрэгжиж байгаа "Статистикийн системийг бэхжүүлэх" төслийн бүрэлдэхүүн хэсэг болох "Нөөц ашиглалтын хүснэгт, Салбар хоорондын баланс байгуулах" төсөл 2002 ондоос хэрэгжиж дууслаа.

Энэ төслийн хүрээнд салбар хоорондын баланс, нөөц ашиглалтын хүснэгтийг 2000 оны байдлаар зохиож, дүнг гаргах зорилт тавьсан. Салбар хоорондын баланс, Нөөц ашиглалтын баланс нь YTC-ийн баланс, тооцооны дэд системд багтдаг хоорондоо нягт уялдаатай биеэ даасан балансууд юм. Нөөц ашиглалтын баланс нь тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, импортын хэмжээ, мөн түүнийг ямар зориулалтаар (завсрын хэрэглээ, эцсийн хэрэглээ, хуримтлал, экспорт) ашиглагв гэдгийг харуулдаг. НАБ, СХБ-ыг зохиосноор ДНБ-ний үйлдвэрлэлт, эцсийн ашиглалтын өнөөгийн тооцооны уялдааг хангах, улмаар мэдээллийн тогтолцоонд үнэлгээ өгч, мэдээллийн хамралтыг сайжруулах нөхцөл бүрдэж байна.

3. УТС-ийг нэвтрүүлэх талаар цаашид хийгдэх ажлын чиглэл

1. YTC-ийн бүрэн нэвтрүүлэх энэхүү өргөн цар хүрээтэй ажлыг хэрэгжүүлэхэд онол, практикийн өргөн мэдлэгтэй дадлага туршлагатай, тодорхой сэдвүүдээр тухайлбал макро эдийн засгийн загвар, прогноз, салбар хоорондын баланс зохиох, судалгаа хийх, эдийн засгийн ангиллуудыг боловсруулах, макро түвшний судалгаа хийх, үндэсний тооцооны дансууд байгуулах чиглэлээр гадаадад нарийн мэргэшүүлсэн ажилтан, нэмэлт орон тоо, хүн хүч зүй ёсоор шаардагдаж байна.

2. Үндэсний тооцооны дансуудыг байгуулах тулгуур мэдээлэл болсон ДНБ-ий тооцооны үнэн бодит байдал, чанарыг дээшлүүлэх талаар ҮСГ-аас ихээхэн анхаарч ирсэн. Гэвч зарим аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа хувийн хэвшлийн байгууллагууд олсон орлого, ашгаа татвараас зайлсхийж нуун дарагдуулах зорилгоор дутуу мэдээлэх явдал түгээмэл байна. Нягтлан болох бүртгэлийн хууль зөрчиж 2-3 еэр тоотой тайлан тэнцэл гаргадаг байгууллагууд ч цөөнгүй байна. Тайлан тэнцлийг санаатайгаар буруу гаргах нь дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд шууд нөлөөлж, түүнийг чанаргүй үндэслэл муутай

болгож байгаа юм. Иймээс бүртгэл, санхүүгийн сахилгыг бэхжүүлэх талаар СЭЗЯ, санхүүгийн улсын хяналтын алба, татварын албадын ажлын уялдааг сайжруулж, хяналт шалгалтыг улам хүчтэй болгох шаардлагатай байгаа юм. Энэ үзэгдэл нь далд эдийн засгийн нэг илрэл болдогийн хувьд түүнийг бүх талаас судалж, улс орны эдийн засагт түүний эзлэх цар хэмжээг бодитой судлан тодорхойлох шаардлага гарч байна.

3. ҮСГ-аас олон улсын статистикийн стандарт, аргачлалд шилжих гол чиглэл болсон үндэсний тооцооны системийг өөрийн орны онцлогт нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх, YTC-ын 1993 оны аргачлалын нэвтрэлтээр Монгол Улсыг 2-р түвшинд оруулахад дараахь гол ажлыг ойрын жилүүдэд хийх шаардлагатай байгаа юм. Үүнд:

- үндэсний тооцооны данснуудыг бүрэн хэмжээгээр байгуулах, үүний дотор эдийн засгийн гадаад харилцааны болон санхүүгийн дансыг иж бүрэн байгуулах,
 - дотоодын нийт бүтээгдэхүүнийг улирлаар тогтмол тооцдог болох,
 - ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоог уlam боловсронгуй болгож, олон улсын жишгээр давхар дефляторын аргыг нэвтрүүлэх, ялангуяа эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий бүрэлдэхүүн хэсгүүдийг зэрэгцүүлэх үнээр үнэлэх,
 - үндсэн ба эргэлтийн хөрөнгийн хуримтлал, үйлчилгээний экспорт, импортын тооцооны хамралтыг сайжруулах,
 - бараа гүйлгээний статистик мэдээллийг бий болгох
 - цаашдаа үндэсний баялгийн тооцоог бий болгох, актив, пассивын тэнцэл зохиох бэлтгэл хангах зэрэг асуудлууд ойрын жилүүдийн нэн тулгамдсан зорилтууд болж байна.